

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тонхил сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/007/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот

2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: [Tserenkhandd@audit.gov.mn](mailto:Tserenkhandd@audit.gov.mn)

Аудитор: Н.Гэрэлмаа

Утас: 99782918 Цахим хаяг: [Gerelmaan@audit.gov.mn](mailto:Gerelmaan@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

---

<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b>	<b>3</b>
<b>3.3.1 Төлбөрийн акт</b> .....	<b>9</b>
<b>3.3.2 Албан шаардлага</b> .....	<b>9</b>
<b>Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	<b>11</b>

---

**Товчилсон үгийн жагсаалт**

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
БХНСС	Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 08. 24 № 139

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тонхил сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд

- Малын тоо, толгойн албан татварын орлого 39.2 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй,
- Хөрөнгийн орлого 78.0 сая төгрөгөөр, газрын төлбөр 0.5 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 0.4 сая төгрөгөөр, торгуулийн орлого 0.1 сая тус тус тасарсан,
- Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 13.6 сая төгрөгийн санхүүжилтийг илүү, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 3.1 сая төгрөгийн, ерөнхий боловсролын сургуульд 67.7 сая төгрөгийн тогтмол зардлын санхүүжилтийг тус тус дутуу олгосон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шагнал урамшуулалд 8.2 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан,

822511000419

- Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 239.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6, 16.5.7, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.5, 41.2.7 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сумын малчдын зөвлөгөөнийг хийж, дээрх арга хэмжээний хүрээнд хойд бүсийн сумдын малчдын дунд малын гаралтай бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан байна. Мөн сумын аварга саальчин болзлын журмыг боловсруулан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 548.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 661.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 33.9 сая төгрөгөөр буюу 121.0 хувьтай биелүүлсэн байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 1,200.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөснийг бүрэн авсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс 191.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 1 хөтөлбөр, 4 зорилт, 132 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 83.2 хувьтай үнэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г. ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,100,090.1	1,297,874.2
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	516,547.6	655,816.8
3	АВЛАГА	45,149.0	66,912.5
4	БАРАА МАТЕРИАЛ	235,376.0	241,496.5
5	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	303,017.5	333,648.5
6	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,416,260.6	2,261,372.8
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,416,260.6	2,261,372.8
8	Биет хөрөнгө	2,388,921.0	2,216,033.2
9	Биет бус хөрөнгө	27,339.6	45,339.6
10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	3,516,350.7	3,559,247.0
11	НИЙТ ӨР ТӨЛБӨР	80,260.2	111,031.4
12	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	80,260.2	111,031.4
13	Өглөг	80,260.2	111,031.4
14	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,436,090.5	3,448,215.6
15	Засгийн газрын хувь оролцоо	3,436,090.5	3,448,215.6
16	Засгийн газрын оруулсан капитал	313,782.5	313,782.5
17	Хуримтлагдсан үр дүн	3,014,862.8	3,026,988.0
18	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	107,445.2	107,445.2
19	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	3,516,350.7	3,559,247.0

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,811,419.3	2,504,024.7
2	ТАТВАРЫН ОРЛОГО	492,075.5	656,361.1
3	Орлогын албан татвар	417,731.4	479,440.3
4	Хувь хүний орлогын албан татвар	447,883.1	536,928.2
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(30,151.7)	(57,487.9)
6	Хөрөнгийн албан татвар	62,443.3	122,745.7
7	Бусад татвар, төлбөр, хураамж	11,900.8	54,175.2
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	560,670.1	1,847,663.6
9	Тусламжийн орлого	-	1,216,076.2
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,758,673.7	-
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,990,108.3	1,995,554.5
12	УРСГАЛ ЗАРДАЛ	1,990,108.3	1,995,554.5
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,950,861.4	1,968,489.5
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	645,332.8	735,101.5
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,583.9	92,193.5
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	574,620.5	603,230.4
17	Хангамж, бараа материалын зардал	67,038.3	47,843.1
18	Эд хогшил, урсгал засварын зардал	170,491.7	65,203.1
19	Томилолт, зочны зардал	3,370.0	2,530.0
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,266.4	7,390.2
21	Бараа үйлчилгээний бусад зардал	335,157.8	414,997.7
22	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,246.9	27,065.0

23	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (Ш)=(1)-(П)	821,311.0	508,470.2
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	429,509.3	488,743.9
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (УИ)=(1У)-(У)	(429,509.3)	(488,743.9)
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (Y1)=(111)+(YП)	391,801.7	19,726.3

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,827,467.8	2,827,467.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	223,034.6	223,034.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,050,502.3	3,050,502.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(6,213.5)	(6,213.5)
5	Тайлант үеийн үр дүн	391,801.7	391,801.7
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,436,090.5	3,436,090.5
7	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,436,090.5	3,436,090.5
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(7,601.1)	(7,601.1)
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,428,489.4	3,428,489.4
10	Тайлант үеийн үр дүн	19,726.3	19,726.3
11	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,448,215.6	3,448,215.6

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,309,350.4	2,329,194.0
2	ТАТВАРЫН ОРЛОГО	492,075.5	656,361.1
3	Орлогын албан татвар	417,731.4	479,440.3
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(30,151.7)	(57,487.9)
5	Хөрөнгийн албан татвар	62,443.3	122,745.7
6	Бусад татвар, төлбөр, хураамж	11,900.8	54,175.2
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,010.8	2,302.6
8	Газрын төлбөр	8,890.0	14,533.3
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	37,339.3
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,601.3	1,672,832.9
11	Нийтлэг татварын бус орлого	58,601.3	39,521.0
12	Тусламжийн орлого	-	1,216,076.2
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	417,235.7
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,758,673.7	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,683,622.9	1,620,368.1
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,683,622.9	1,620,368.1
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,644,376.0	1,593,303.1
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	625,553.0	730,590.8
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,097.9	92,193.5
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	519,474.9	590,281.4
21	Хангамж, бараа материалын зардал	69,213.3	24,884.9
22	Эд хогшил, урсгал засварын зардал	178,769.0	69,724.9
23	Томилолт, зочны зардал	3,370.0	2,530.0
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,785.3	4,390.2
25	Бараа үйлчилгээний бусад зардал	58,112.7	78,707.5

26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,246.9	27,065.0
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (111)=(1)-(11)	625,727.5	708,825.9
28	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	525,919.7	569,556.7
29	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	525,919.7	569,556.7
30	Дотоод эх үүсвэрээр	525,919.7	569,556.7
31	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Y1)=(1Y)-(Y)	(525,919.7)	(569,556.7)
32	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,203.0	-
33	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(1,203.0)	-
34	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Y111)=(111)+(Y1)+(Y11)	98,604.8	139,269.2
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	417,942.8	516,547.6
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	516,547.6	655,816.8

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,170,076.30	2,310,493.57	(140,417.27)	106.5
11	Татварын орлого	543,425.30	656,361.12	(112,935.82)	120.8
110	Орлогын албан татвар	428,364.30	479,440.32	(51,076.02)	111.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	485,852.20	536,928.22	(51,076.02)	110.5
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	292,511.70	372,751.44	(80,239.74)	127.4
110002	Үйл ажиллагааны орлого	26,952.50	32,761.37	(5,808.87)	121.6
110003	Хөрөнгийн орлого	165,402.10	87,380.36	78,021.74	52.8
110008	Шууд бус орлого	985.90	44,035.05	(43,049.15)	4,466.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(57,487.90)	(57,487.90)	-	100.0
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(57,487.90)	(57,487.90)	-	100.0
113	Хөрөнгийн албан татвар	69,905.00	122,745.66	(52,840.66)	175.6
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	6,500.00	12,397.12	(5,897.12)	190.7
113002	Бууны албан татвар	3,405.00	7,145.50	(3,740.50)	209.9
113004	Малд ногдуулах албан татвар	60,000.00	103,203.04	(43,203.04)	172.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	45,156.00	54,175.15	(9,019.15)	120.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,700.00	2,302.56	397.44	85.3
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,700.00	2,287.56	412.44	84.7
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	-	15.00	(15.00)	
1181	Газрын төлбөр	15,000.00	14,533.34	466.66	96.9
118101	Газрын төлбөр	15,000.00	14,533.34	466.66	96.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	27,456.00	37,339.25	(9,883.25)	136.0
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	27,456.00	37,339.25	(9,883.25)	136.0
12	Татварын бус орлого	1,626,651.00	1,654,132.45	(27,481.45)	101.7

120	Нийтлэг татварын бус орлого	5,056.00	36,751.95	(31,695.95)	726.9
120003	Торгуулийн орлого	5,056.00	4,969.00	87.00	98.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	-	31,747.95	(31,747.95)	
120009	Бусад орлого	-	35.00	(35.00)	
122	Тусламжийн орлого	1,200,144.80	1,200,144.80	-	100.0
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	1,200,144.80	1,200,144.80	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	-	-	-	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	421,450.20	417,235.70	4,214.50	99.0
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	421,450.20	417,235.70	4,214.50	99.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	421,450.20	2,171,118.60	(1,749,668.40)	515.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	(474,159.50)	1,603,911.90	(2,078,071.40)	(338.3)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,666,265.60	1,576,846.90	89,418.70	94.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	728,893.30	728,811.62	81.68	100.0
210101	Үндсэн цалин	463,085.90	462,781.59	304.31	99.9
210102	Нэмэгдэл	265,807.40	266,030.03	(222.63)	100.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,194.00	92,193.50	0.50	100.0
210201	Тэтгэврийн даатгал	63,196.60	63,196.60	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,249.40	7,249.40	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,624.70	3,624.70	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,624.70	3,624.70	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,498.60	14,498.10	0.50	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	620,669.10	590,281.42	30,387.68	95.1
210301	Гэрэл, цахилгаан	37,678.10	35,847.61	1,830.49	95.1
210302	Түлш, халаалт	582,991.00	554,433.81	28,557.19	95.1
2104	Хангамж, бараа материалын зардал	39,899.20	21,100.25	18,798.95	52.9
210401	Бичиг хэрэг	3,632.80	2,056.50	1,576.30	56.6
210402	Тээвэр, шатахуун	31,700.00	16,167.75	15,532.25	51.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200.00	955.90	244.10	79.7
210404	Ном, хэвлэл	500.00	-	500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200.00	-	200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,666.40	1,920.10	746.30	72.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,000.00	59,539.10	2,460.90	96.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000.00	-	2,000.00	-
210604	Урсгал засвар	60,000.00	59,539.10	460.90	99.2
2107	Томилолт, зочны зардал	4,331.60	2,530.00	1,801.60	58.4
210702	Дотоод албан томилолт	4,331.60	2,530.00	1,801.60	58.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,100.00	1,333.47	3,766.53	26.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000.00	685.74	1,314.26	34.3
210803	Даатгалын үйлчилгээ	300.00	255.15	44.85	85.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000.00	238.58	761.42	23.9

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300.00	154.00	146.00	51.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500.00	-	1,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,178.40	81,057.54	32,120.86	71.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	108,978.40	80,041.04	28,937.36	73.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,200.00	1,016.50	3,183.50	24.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	(2,140,425.10)	27,065.00	(2,167,490.10)	(1.3)
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	(2,170,765.10)	-	(2,170,765.10)	-
213103	Төсвийн санхүүжилт	(2,170,765.10)	-	(2,170,765.10)	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,340.00	27,065.00	3,275.00	89.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,740.00	25,740.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,600.00	1,325.00	3,275.00	28.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	711,913.30	567,206.70	144,706.60	79.7
223001	Бусад хөрөнгө	711,913.30	567,206.70	144,706.60	79.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	183,696.40	-	183,696.40	-
230001	Эргэж төлөгдөх зээл	183,696.40	-	183,696.40	-
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,748,626.10	139,374.97	1,609,251.13	8.0
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,748,626.10)	(139,374.97)	(1,609,251.13)	8.0
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,748,626.10)	(139,374.97)	(1,609,251.13)	8.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	504,851.23	(504,851.23)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	641,316.38	(641,316.38)	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	ТЗ цэвэр дүн
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	22,495.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,495.0
122	Тусламжийн орлого	22,495.0
1221	Хандив тусламж /дотоод/	22,495.0
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,495.0
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,847.2
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,647.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,806.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,806.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,806.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,779.1
210101	Үндсэн цалин	579.1
210105	Гэрээт ажлын хөлс	1,200.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,784.6
210402	Тээвэр, шатахуун	3,534.6

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,185.8
210604	Урсгал засвар	10,185.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,056.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,056.7
4	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,688.8

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тонхил сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 5 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Бага сургууль) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн ба сумын ИТХ, ХХС, БХНСС, ОНХС, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, бага сургуулийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

### 3.1 Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 1,139.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 4 алдааг залруулж, 1.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 12.4 сая төгрөгийн 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

### 3.2.Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналыг 804.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 11 алдааг залруулж, 4.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 168.7 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага, 50.4 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

### 3.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

- ✓ Аудитаар нийт 99.7 сая төгрөгийн 3 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна.

Залруулсан алдаа:

#### Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Санхүүгийн тайланд ИТХ-ын бусад авлагыг 0.7 сая төгрөгөөр, борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгийг 30.6 сая төгрөгөөр, тайлант үеийн үр дүнг 44.4 сая төгрөгөөр тус тус дутуу, ОНХС-гийн хувь хүмүүсээс авах авлагыг 0.6 сая төгрөгөөр, ИТХ-ын байгууллагад төлөх өр төлбөрийг 6.2 сая төгрөгөөр, өмнөх үеийн үр дүнг 6.8 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд ОНХС-гийн үндсэн үйл ажиллагааны орлогыг 5.4 сая төгрөгөөр, бусад зардлыг 5.4 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээг 5.4 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнасныг залруулсан.

#### Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:

- Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 4,115.6 сая төгрөгийн 180 мэдээллээс бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад

хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 4.9 сая төгрөгийн 1 мэдээллийг мэдээлээгүйг нөхөн байршууллаа.

Аудитаар залруулагдаагүй нийт 462.1 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшингөөс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 462.1 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс, 1 төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 3 зөвлөмжийг хүргүүлсэн.

### 3.3.1 Төлбөрийн акт

Нэг. Малын тоо толгойн албан татварын орлого 39.2 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна"-д заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн 39.2 сая төгрөгийг Тонхил сумын Төрийн сан дахь Га.Тонхил ОНХС 100050952400 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт хүргүүлсэн.

### 3.3.2 Албан шаардлага

Нэг. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 239.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 5.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 168.7 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 62.9 сая төгрөгийн 6 зөвлөмж, 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 2.4 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-т "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### 3.3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. **Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Нэг. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөнөөс мөсний баярын арга хэмжээнд 3.2 сая төгрөг, халз ЭЕШ арга хэмжээний тест авахад 2.5 сая төгрөг, шагналд 2.1 сая төгрөг, эмэгтэйчүүдийн баярын арга хэмжээний хоол, хүнсэнд 0.4 сая төгрөг, авто тээврийн 100 жилийн ойн арга хэмжээ, шагнал урамшуулалд 3.4 сая төгрөг, ГАА-2026/007/НА-СТА-ТТЗ

"Сүрлэг сүтэйн түрлэг" уран үгсийн чуулганы арга хэмжээ, шагнал урамшуулад 8.2 сая төгрөгийг тус тус үр ашиггүй зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Хоёр. Сумын орон нутгийн төсвөөс ЗДТГ-т 13.6 сая төгрөгийн санхүүжилтийг илүү, ИТХ-д 3.1 сая төгрөгийн, ерөнхий боловсролын сургуульд 67.7 сая төгрөгийн тогтмол зардлын санхүүжилтийг тус тус дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Тонхил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 15 дугаар тогтоол"-той нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хуваарийн дагуу нэгж байгууллагуудад санхүүжилтийг олгож байх.

Гурав. Хөрөнгийн орлого 78.0 сая төгрөгөөр, газрын төлбөр 0.5 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 0.4 сая төгрөгөөр, торгуулийн орлого 0.1 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Тонхил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 12 дугаар тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****᠖.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл****(мянган төгрөг)**

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тонхил сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	3	99,657.7	1	4,935.0	2	94,722.7	3	99,657.7	-	-	-	-
Тонхил сумын ЗДТГ	4	1,139,018.9	1	1,097,358.3	3	41,660.6	4	1,139,018.9	-	-	-	-
Тонхил сумын ИТХ	1	6,218.5	-	-	1	6,218.5	1	6,218.5	-	-	-	-
Тонхил сумын ОНХС	8	728,866.0	1	24,200.0	7	704,666.0	8	728,866.0	-	-	-	-
Тонхил сумын ХХС	2	69,773.4	-	-	2	69,773.4	2	69,773.4	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>18</b>	<b>2,043,534.5</b>	<b>3</b>	<b>1,126,493.3</b>	<b>15</b>	<b>917,041.2</b>	<b>18</b>	<b>2,043,534.5</b>	-	-	-	-

## 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түүвэрт	Нийт зөрчил		Үүнээс									
									Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тонхил сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1	-	1	-	-	-	5	462,121.4	1	39,236.0	1	239,722.2	3	183,162.5	-	-	-	-
Тонхил сумын ЗДТГ	1	-	1	-	-	-	4	13,586.9	1	1,140.0	-	-	3	12,446.9	-	-	-	-
Тонхил сумын ИТХ	1	-	-	-	-	1	1	2,385.0	-	-	-	-	-	1	2,385.0	-	-	
Тонхил сумын ОНХС	1	-	-	-	-	1	1	10,000.0	-	-	1	10,000.0	-	-	-	-	-	-
Тонхил сумын БХНСС	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Тонхил сумын ХХС	1	-	-	-	-	1	2	5,436.5	1	4,615.1	-	-	1	821.4	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>13</b>	<b>493,529.8</b>	<b>3</b>	<b>44,991.1</b>	<b>2</b>	<b>249,722.9</b>	<b>7</b>	<b>196,430.8</b>	<b>1</b>	<b>2,385.0</b>	<b>-</b>	<b>-</b>

## 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тонхил сумын ОНХС	3	208,314.5	-	-	3	208,314.5	2	49,625.0
	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>208,314.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>208,314.5</b>	<b>2</b>	<b>49,625.0</b>

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ		1				1		
	<b>НИЙТ</b>		<b>1</b>				<b>1</b>		